

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж
арга хэмжээ авч ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.3.3, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1, 32 дугаар зүйлийн 32.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн 7, 8, 12, 17, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт булгийн ус, газрын хөрснөөс нэвчин урссаны улмаас айл өрх, гудамж, зам, талбай усанд автаж, хөлдөлт үүссэн, цаашид усны түвшин нэмэгдэх төлөвтэй, ард иргэдийн байшин, гэрт ус орж эд хөрөнгөнд хохирол учрах эрсдэлтэй байгаа тул Үер ус, хөлдөлт, ус, цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах шуурхай ажлын хэсгийг 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, яаралтай арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн Онцгой комиссын Үер ус, хөлдөлт, ус, цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах шуурхай ажлын хэсэг /Ч.Цогтбаяр/-т, Онцгой комиссын орлогч дарга /С.Эрдэнэбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

2. Булгийн ус, газрын хөрснөөс нэвчин урссаны улмаас айл өрх, гудамж, зам, талбай усанд автаж, хөлдөлт үүссэн нөхцөл байдлын голомтын бүсэд зөвшөөрөгдсөн газрын хэмжээг дур мэдэн сунгаж хашаалсан, зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй айл өрхүүдийн газрыг чөлөөлөх, албадан буулгах, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг дүүргийн Газрын алба /Ж.Мөнх-Эрдэнэ/-д, дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хүн, хүч, техник хэрэгслээр хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс /С.Эрдэнэбаяр/-т, Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК /Э.Ганчимэг/-д тус тус үүрэг болгосугай.

3. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэх үеийн хэв журам сахиулж, иргэдийн өмч, эд хөрөнгийг хамгаалах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, урьдчилан сэргийлж ажиллахыг Цагдаагийн нэгдүгээр хэлтэс /Ө.Эрдэнэхүү/-т, Цагдаагийн хоёрдугаар хэлтэс /Ц.Сугаржав/-т Замын цагдаагийн хэлтэс /Д.Ганболд/-т тус тус даалгасугай.

4. Аюулт үзэгдлийн бүсэд халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж ариутгал халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын хэлтэс /Д.Хишигбаатар/-т, шаардлагатай иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төв /Ц.Лхагва/-д тус тус даалгасугай.

5. Булгийн ус, газрын хөрснөөс нэвчин урссаны улмаас айл өрх, гудамж, зам, талбай усанд автаж, хөлдөлт үүссэн газарт шинээр үер усны далан суваг, авто зам,

явган хүний замын ажлын зураг төслийг холбогдох байгууллагатай хамтран хийхийг Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс /А.Гэрэлт-Од/-т даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ж.Лхагвасүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ